

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, Банкны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэг, “Төрийн банк” ХК-ийн дүрмийн 10.13.7 дахь заалт, 24.1 дэх хэсэг, “Төрийн Банк” ХК-ийн “Ногдол ашгийн бодлого”-ын 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Төрийн Банк” ХК-ийн 2022 оны татварын дараах цэвэр ашгийн 50 /тавы/ хувийг нийт эргэлтэд байгаа 755,096,250 ширхэг энгийн хувьцаанд мөнгөн хэлбэрээр ногдол ашиг болгон хуваарилсугай.

2. Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн дүнг 63.68 /жаран гурван төгрөг жаран найман мөнгө/ төгрөг байхаар тогтоосугай.

3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.

4. Ногдол ашгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан эрх бүхий байгууллагын зөвшөөрөл ирснээс хойш 60 хоногийн дотор олгохыг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д даалгасугай.

5. Ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын Хөрөнгийн бирж” ХК-д хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д даалгасугай.

6. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга /Б.Тэлмүүн/-д даалгасугай.

7. Энэ тогтоолын хувийг Монголбанк, Санхүүгийн Зохицуулах хороо, “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-д тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д даалгасугай.

8. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга /Б.Тэлмүүн/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ТЭЛМҮҮН